

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллага сонгох тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.9 дахь заалтыг үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. “Тандэм Инвэст ББСБ” ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Шинэ их тэрбум аудит” ХХК-ийг сонгосугай.
2. “Шинэ их тэрбум аудит” ХХК-тай байгуулах гэрээний нөхцөлийг хэлэлцэн тохирох, гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Золжаргал/-д олгосугай.
3. Хөндлөнгийн аудитын байгууллагыг төлөвлөсөн хугацаанд ажиллах нөхцөл боломжоор хангаж, хамтарч ажиллах, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөх, тайланг төлөвлөсөн хугацаанд нийтлэхэд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Золжаргал/-д үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Компанийн бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн батлах тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.21 дэх заалтыг үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. “Тандэм Инвэст ББСБ” ХК-ийн удирдлага зохион байгуулалтын бүтцийг нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Батлагдсан бүтэц орон тоог мөрдөн ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Золжаргал/-д даалгасугай.



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ



Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн
2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн
02 тоот тогтоолын Хавсралт №1



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.11 дэх заалтыг үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Компанийн оноосон нэрийг Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01 сарын 15-ны өдрийн 06 тоот тушаалаар “Тандэм Инвэст ББСБ” ХК болгон өөрчилсөнтэй холбогдуулан дараах журмуудыг шинэчлэн баталсугай. Үүнд:

- Хавсралт 1 Хөдөлмөрийн дотоод журам
- Хавсралт 2 Компанийн ёс зүйн дүрэм
- Хавсралт 3 Комплайнсын хөтөлбөр
- Хавсралт 4 Комплайнсын сургалтын хөтөлбөр
- Хавсралт 5 Зээлийн мэдээллийн сангийн журам
- Хавсралт 6 Нягтлан бодох бүртгэлийн заавар
- Хавсралт 7 Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам
- Хавсралт 8 Мэдээллийн үйл ажиллагааны журам
- Хавсралт 9 Авлигын эсрэг журам
- Хавсралт 10 Сонирхлын зөрчлийг тодорхойлох, сэргийлэх, мэдээлэх журам

2. Журмыг мөрдөн ажиллахыг нийт ажилтнуудад үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Салбар нэгж татан буулгах тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.212.21 дэх заалтыг үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. “Тандэм Инвэст ББСБ” ХК-ийн Завхан аймгийн Улиастай хотод байрлалтай салбар нэгжийг татан буулгасугай.
2. Холбогдох эрх бүхий байгууллагад албан ёсоор бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Золжаргал/-д үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ